

2025 ОНЫ 08 ДУГААР САРЫН 26-НЫ ӨДРИЙН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

2025-08-27

Өндөртөлгой

Үүргийн биелэлтийг Arial-11, 12 фонтоор бичиж, **2025 оны 09 дүгээр сарын 02-ны “Мягмар” гарагт** Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн (ERP Б.Одбаяр)-д албан бичгээр болон word файлаар ирүүлнэ үү.

Нийслэл, дүүргийн удирдлагаас цаг үеийн холбогдолтой өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд онцгой анхаарч биелэлтийг ирүүлэхдээ нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1106 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-ын 8.6 дахь хэсэгт заасан дараах шаардлагын дагуу тайлагнахыг анхаарна уу

8.6.Байгууллагаас ирүүлэх бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, холбогдох тайлан, мэдээ нь дараах шаардлагыг хангасан байна:

- 8.6.1. үйл ажиллагааны гүйцэтгэлийг бүрэн багтаасан, тайлант хугацааг бүрэн хамруулсан байх;
8.6.2. үг үсгийн болон хэл найруулгын хувьд алдаагүй, тоо баримт зөрөөгүй байх;
8.6.5. тайлан дахь хүрсэн түвшний талаарх мэдээллийн үнэн, зөв эсэхийг нягтлан шалгасан байх;
8.6.6. хийсэн ажлыг бүрэн хамруулж, үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийн үндэслэл, шалтгааныг тодорхой гаргасан байх;
8.6.7. хэрэгжилтийг 2000 (хоёр мянган) тэмдэгтэд багтааж, үр дүн, үр нөлөөг тайлагнах;

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГАААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
1	Дүүргийн хэмжээнд борооны усны хаялгын чиглэлээр өргөтгөсөн бүрэлдэхүүнтэй үзлэг шалгалтыг зохион байгуулах, 2026 онд дүүрэгт хийгдэх ус зайлуулах хоолой, шугам сүлжээний талаар танилцуулах;	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ, ОБХ, Хороод, Багахангай тохижилт ОНӨААТҮГ, холбогдох Ажлын хэсэг
2	Шинээр худалдан авсан хот, нийтийн аж ахуйн машин, техник, тоног, төхөөрөмжийг ажилд нь гаргах;	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ
3	Хөдөлгөөний ачаалал нэмэгдэж байгаатай холбогдуулан гэмт хэрэг, хэв журмын зөрчил болон зам, тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах;	Цагдаагийн хэлтсийн Замын цагдаагийн хэсэг
4	Нийтийн эзэмшлийн зам талбай, хайс, хашлага, бродюр, замын хаалтуудыг мөргөж эвдэлж байгаа тээврийн хэрэгслүүдийг хиймэл оюун ухаанаар бүртгэж, тухай бүрт Замын цагдаагийн байгууллагууд шилжүүлж, засварлуулдаг байх;	Цагдаагийн хэлтсийн Замын цагдаагийн хэсэг, “Багахангайн Теле камерын хяналтын дэд төв” ОНӨААТҮГ
5	Сургууль, цэцэрлэгийн бэлэн байдлыг хангаж, засвар, шинэчлэлийн ажлыг хийж дуусгах, багшлах боловсон хүчний хангалтыг хэвийн болгоход анхаарч ажиллах;	НХХ, Боловсролын хэлтэс, ЕБС, СӨББ-ууд
6	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хоол, хүнсний, бараа бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн шаардлага, стандартыг мөрдүүлж, аюулгүй байдлыг хангуулах хяналт шалгалтыг хийх;	НХХ, Боловсролын хэлтэс, Холбогдох Ажлын хэсэг
7	Дүүргүүд борооны улмаас эвдэрч гэмтсэн автозам, гудамж, талбай, ногоон байгууламжуудаа нөхөн сэргээх ажлуудаа эрчимжүүлэх;	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ, Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ
8	Үерийн аманд байгаа айл, өрхүүдийг нүүлгэн шилжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах;	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ, ОБХ, Хороод
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
9	Шаардлагатай байршлуудад суваг шуудуу татаж, ус зайлуулах хоолой хийх;	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ, ОБХ, Хороод, Багахангай тохижилт ОНӨААТҮГ
10	Дүүргийн 2026 оны тохижилтын ажлын төлөвлөлт боловсруулах;	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ, Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ
11	Дүүргийн хэмжээнд 2026 онд нэмэгдүүлэх шаардлагатай камерын байршил, тоо хэмжээ, төсвийг боловсруулж, танилцуулах;	Цагдаагийн хэлтэс, “Багахангайн Теле камерын хяналтын дэд төв” ОНӨААТҮГ, Хороод

12	Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд үйлдэгдэж буй зөрчлүүдийг камерын тусламжтайгаар хянаж, холбогдох хариуцлагын тогтолцоог хэрэгжүүлэх;	Цагдаагийн хэлтэс, “Багахангайн Теле камерын хяналтын дэд төв” ОНӨААТҮГ
13	Дүүргийн 2025-2026 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээний гүйцэтгэл, биелэлтэд анхаарч, эрчимжүүлэх;	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ, инженерийн хангамжийн байгууллагууд
14	Дүүрэгт нийтийн тээврийн автобусны зогсоол байгуулахтай холбогдуулан Нийтийн тээврийн бодлогын газарт холбогдох саналын хүргүүлэх;	ТХҮХ
15	Улс, нийслэл, дүүргийн төсвийн орлогын бүрдүүлэлтийг жигд ханган биелүүлэх;	СТСХ, Татварын хэлтэс
16	2025-2026 оны хичээлийн жилд хэрэгжих “Сүү” хөтөлбөрийн бэлтгэлийн талаар танилцуулах;	ЗДО Х.Цогцэцэг, НХХ, Боловсролын хэлтэс, ЕБС, СӨББ-ууд
17	Хороодод хийгдэж буй хөрөнгө оруулалтын ажлуудыг эрчимжүүлэх;	Хороод
18	Дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайг машин механизм ашиглан угааж цэвэрлэх;	Багахангай тохижилт ОНӨААТҮГ
19	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар болон Нотариатчдын танхим руу хүсэлт явуулах;	ЗДТГ, Нийгмийн даатгалын газар
20	Дүүрэгт хөрөнгө оруулалтаар хийгдэж буй томоохон ажлууд болон, зохион байгуулагдаж буй томоохон ажил, арга хэмжээнүүдийг архивлах;	Архивын хэлтэс
21	ААНБ-уудаас дүүрэгт хувийн орон сууц барих хүсэлт олноор ирүүлж байгаатай холбогдуулан тэдгээрийн дунд сонгон шалгаруулалт зарлах эрх зүйн орчныг бүрдүүлэх;	ЗДО Х.Цогцэцэг, ТЗУХ, ХААА

ТАНИЛЦСАН
ЗАСАГ ДАРГА

А.СҮХБОЛД

ХЯНАСАН
ГАДААД ХАРИЛЦАА ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Б.ГЭРЭЛЦОЛМОН

БОЛОВСРУУЛСАН
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Б.ОДБАЯР